

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухаан спорт
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт
НББСШУ	Нийгмийн бодлого боловсрол соёл шинжлэх ухаан
УИХ	Улсын Их Хурал
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  
Ц.ПҮРЭВХҮҮ ТАНАА

2019.02.25 № 06/238  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Консерваторийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Консерваторийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Консерваторийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Монгол Улсын Консерваторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын Консерваторийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Пүрэвхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Консерваторийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Консерваторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 03-наас 2019 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Юнистар Аудит ХХК-ийн аудитор М.Энхжаргал ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Консерватори 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн № 68 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Улсын Консерваторийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Монгол Улсын Консерватори нь тогтвортой хөгжих нөхцөлийг хангасан Зүүн хойд Азийн тэргүүлэх Консерваториудын нэг болно гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

БШУС-ын сайдын 2014 оны А/78, БСШУС-ын сайдын 2017 оны А/84 дугаар тушаалаар Монгол Улсын Консерваторийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөгжмийн дээд боловсрол олгох

Монгол Улсын Консерваторийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол Улсын Консерваторийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Мэргэжлийн боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Монгол улсын Консерваторийн Удирдах зөвлөлийн 2018 оны 03 сарын 07-ны 03 тоот тогтоолоор Консерваторийн дүрэм, бүтцийг шинээр баталсан.
- УИХ-ын НББСШУ-ны Байнгын хорооны 2018 оны 05.15-ны өдрийн 13 тоот “Монгол улсын консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол гарч БСШУСЯ болон тус сургууль дээр ажлын хэсэг байгуулагдан ажилласан байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Монгол Улсын Консерваторийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлаггүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Консерватори санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

Монгол Улсын Консерваторийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Монгол Улсын Консерваторийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо



олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

*Нийт орлогыг* материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсөвт байгууллагын үйл ажиллагааг илүү сайн илэрхийлж чадах үзүүлэлт нь төсвийн санхүүжилтийн хэмжээ байдаг ба төсвийн орлогын үзүүлэлтийн 1 хувиас хэтрэхгүй дүнг материаллаг бус гэж үзлээ.

Монгол Улсын Консерваторийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн нийт орлого 3,986,713.3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 39,867.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/Мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	979.1	
	Дүн	2	979.1	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.

## 2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал ажиглагдаагүй.

## 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монгол Улсын Консерваторийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 3,726,790.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 64,716.1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт орсон. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 3,701,537.0 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь төсөв хэтрээгүйг харуулж байна. Харин зарим зардлууд хэтэрсэн харагдах боловч энэ нь төсвийн бүлэг дотор гүйлгэн шилжүүлж зарцуулдаг зардлууд байна.

Өөрийн орлогын хэмжээг 25,330.6 мянган төгрөгөөр буюу 6.19 хувиар давуулан биелүүлсэн байна. Энэ нь оюутан суралцагчдын тоо, сургалтын нэг цагийн кредитийн төлбөр нэмэгдсэн, сургалтын үйл ажиллагаа өргөжсөнтэй холбоотой байна.

## 2.11 Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Консерватори нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Монгол Улсын Консерватори нь 2018 онд Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан байна.

Монгол Улсын Консерватори нь “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”, Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны ил тод байдлыг

хангах зарчмын дагуу 2018 онд 403,802.9 мянган төгрөгийн 148 мэдээллийг шилэн дансны цахим хаягаар улирал бүрийн хуулийн хугацаанд илгээж ажилласан байна.

Үүнд тендерт оролцсон нарийн мэдээллийн тухай 26 удаа, 5 саяас дээш худалдан авалтын тухай 12 удаа, Цалингийн зардлаас бусад 5 саяас дээш орлого, зарлагын гүйлгээг 12 удаа, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаар 60 удаа, нийтийн ашиг сонирхлоос сэргийлэх тухай 12 удаа, бусад мэдээллийг 26 удаа цахим хуудсанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар хоёр зөвлөмж өгсөн бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Монгол Улсын Консерваторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын Консерваторийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Консерваторийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Үндсэн хөрөнгийн талаар**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгөнд 979.1 мянган төгрөгийн 3 нэр төрлийн хөрөнгөнд цаашид ашиглах жилийг нь оруулаагүйгээс элэгдэл тооцоолж бодоогүй байна. Мөн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө их байна.

Энэ нь иж бүрэн байх, хэмжилт, үнэлгээ тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС 17-ийн 66-д хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр элэгдүүлнэ, мөн энэ стандартын 13-д Ашиглалтын хугацаа гэдэг нь а/байгууллагаас хөрөнгийг ашиглах боломжтой хугацаа, эсвэл байгууллага тухайн хөрөнгийг ашиглан үйлдвэрлэхээр хүлээгдэж буй бүтээгдэхүүн эсвэл түүнтэй адилтгах зүйлийн тоо хэмжээ байна гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй орхигдуулах

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

УСНББОУС 17-д зааснаар хөрөнгийн ашиглалтын хугацааг байгууллагын оруулах хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын нөхцөлөөр тодорхойлох, тусгайлсан бодлогыг НБББББ-тээ тодорхойлж, байгууллагадаа тууштай мөрдөн ажиллах

### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үндсэн хөрөнгийн талаар илрүүлсэн 3 нэр төрлийн 979,145 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн ашиглалтын жил оруулаагүйгээс элэгдэл тооцоогүй байсныг хүлээн зөвшөөрч элэгдлийг 2019 оны 1-р сарын 01-нээс эхлэн тооцож эхэлнэ. Элэгдлээ нөхсөн боловч хөрөнгийн онцлогоос шалгаалж олдоц болон төсөв мөнгөтэй холбоотойгоор авч чадахгүй байгаа европт үйлдвэрлэсэн төгөлдөр хуур хөгжим болон гуулин үлээвэр гэх мэт хөгжмүүдийг шууд актлах буюу шинээр үнэ тогтоох боломж муутай байдаг.

## **3.2 Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж**

### 3.2.1 Илрүүлэлт:

Нярав нь санхүүгийн програмгүй, анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн, мөн тайлангийн эхний үлдэгдлийг хураангуй зөвхөн орлого, зарлага гаргасан бараа материалын үлдэгдлээр бүртгэж байна.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Няравын програмгүйгээс анхан шатны баримтыг дутуу бүрдүүлэх

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн програмд няравын програмыг суулган, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Няравын програмтай болох талаар судлан ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>156,183,508.41</u></b>	<b><u>141,076,526.90</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	334,920.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	334,920.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	334,920.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	334,920.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	156,183,508.41	140,741,606.90
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	15,922,153.00	16,435,394.00
35110	Тусгай зориулалттай материал	15,724,353.00	16,285,394.00
35130	Эм боох материал	197,800.00	150,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	140,261,355.41	124,306,212.90
35410	Бичиг хэргийн материал	3,834,800.00	4,543,900.00
35420	Аж ахуйн материал	127,756,114.41	110,947,427.90
35430	Сэлбэг хэрэгсэл	1,070,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	-	26,180.00
35470	Бусад хангамжийн материал	7,600,441.00	8,788,705.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,945,341,405.30</u></b>	<b><u>11,632,587,097.13</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,945,341,405.30	11,632,587,097.13
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5,941,887,405.30	10,796,238,697.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,351,651,681.00	9,503,526,410.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,676,000,003.66	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	25,700,000.00	25,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,979,999.72	-23,219,999.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,864,477,180.04	2,058,060,609.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-989,412,198.46	-1,119,219,384.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	690,650,520.86	717,746,770.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-428,015,072.08	-494,379,807.19
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,952,942.40	22,952,942.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-21,864,942.40	-21,864,942.40
39217	Ном	123,727,297.32	126,936,097.32
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,454,000.00	836,348,399.96
39301	Програм хангамж	6,134,000.00	15,334,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,680,000.00	-4,028,000.04
39303	Бусад биет бус хөрөнгө	-	825,042,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>6,101,524,913.71</u></b>	<b><u>11,773,663,624.03</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>83,500.00</u></b>	<b><u>539,900.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	83,500.00	539,900.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	83,500.00	539,900.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	83,500.00	539,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	83,500.00	539,900.00

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>6,101,441,413.71</u></b>	<b><u>11,773,123,724.03</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,101,441,413.71	11,773,123,724.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,185,390,255.62	8,010,432,655.62
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	7,185,390,255.62	8,010,432,655.62
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-1,275,808,134.95	-1,362,871,819.50
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,275,808,134.95)	-1,275,808,134.95
51220	Тайлант үеийн үр дүн	-	-87,063,684.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	191,859,293.04	5,125,562,887.91
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>6,101,524,913.71</u></b>	<b><u>11,773,663,624.03</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,937,256,582.00</b>	<b>4,041,883,389.17</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>703,316,444.00</b>	<b>579,427,926.17</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	703,316,444.00	460,510,540.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	703,316,444.00	460,510,540.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	321,567,189.00	409,169,851.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,277,617.00	29,632,825.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	356,471,638.00	21,707,864.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	118,917,386.17
122001	Хандив тусламж /дотоод/	-	118,917,386.17
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,233,940,138.00</b>	<b>3,462,455,463.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,208,697,250.00	3,397,652,921.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,208,697,250.00	3,317,818,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	79,500,001.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	334,920.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	25,242,888.00	64,802,542.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,242,888.00	64,802,542.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,836,163,946.65</b>	<b>4,128,947,073.72</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,836,163,946.65</b>	<b>4,128,947,073.72</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,669,412,776.65	3,915,634,577.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,629,079,802.85	2,675,185,082.09
210101	Үндсэн цалин	2,629,079,802.85	2,675,185,082.09
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	290,664,263.23	310,190,235.33
210201	Тэтгэврийн даатгал	246,412,528.21	265,345,637.02
210205	Эрүүл мэндийн даатгал	44,251,735.02	44,844,598.31
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	285,735,344.08	296,570,906.85
210301	Гэрэл, цахилгаан	45,968,400.00	49,842,050.00
210302	Түлш, халаалт	73,632,886.00	77,303,860.00
210303	Цэвэр, бохир ус	16,134,058.08	19,424,996.85
210304	Байрны түрээс	150,000,000.00	150,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,259,301.00	75,647,490.42
210401	Бичиг хэрэг	3,331,097.00	11,659,010.00
210402	Тээвэр, шатахуун	2,304,804.00	1,666,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,179,500.00	9,044,500.00
210404	Ном, хэвлэл	443,900.00	1,314,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,412,000.00



Монгол Улсын Консерваторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	50,152,590.42
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	398,160.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	26,075,675.00	39,427,743.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	197,800.00
210502	Хоол, хүнс	26,075,675.00	38,891,943.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	338,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,238,700.00	54,113,630.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,810,000.00
210604	Урсгал засвар	4,238,700.00	52,303,630.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	604,000.00	759,900.00
210702	Дотоод албан томилолт	604,000.00	759,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	76,105,050.00	87,459,918.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,077,169.00	76,964,118.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	10,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,040.00	198,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,897,041.00	297,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	341,650,640.49	376,279,672.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,917,680.84	12,839,411.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,310,724.00	58,851,479.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	283,422,235.65	304,588,782.30
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	166,751,170.00	213,312,495.73
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	166,751,170.00	158,142,414.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,184,920.00	24,674,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,566,250.00	133,468,214.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	72,000,000.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	55,170,081.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		55,170,081.73
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>101,092,635.35</u></b>	<b><u>(87,063,684.55)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>101,092,635.35</u></b>	<b><u>(87,063,684.55)</u></b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>3,635,951,960.43</u></b>	<b><u>3,821,758,138.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>361,005,602.43</b>	<b>438,802,676.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	361,005,602.43	438,802,676.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	361,005,602.43	438,802,676.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	321,567,189.00	409,169,851.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,438,413.43	29,632,825.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,274,946,358.00</b>	<b>3,382,955,462.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,208,697,250.00	3,318,152,920.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,208,697,250.00	3,317,818,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	334,920.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	25,242,888.00	64,802,542.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,242,888.00	64,802,542.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	41,006,220.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	41,006,220.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>3,620,180,580.35</u></b>	<b><u>3,796,799,118.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,620,180,580.35</b>	<b>3,796,799,118.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,437,883,729.51</b>	<b>3,583,486,622.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,670,086,022.85	2,674,645,182.09
210101	Үндсэн цалин	1,882,742,822.85	1,931,063,960.48
210102	Нэмэгдэл	611,251,900.00	643,391,221.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	176,091,300.00	80,190,000.00
210104	Урамшуулал	-	20,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	290,664,263.23	310,190,235.33
210201	Тэтгэврийн даатгал	290,664,263.23	310,190,235.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	285,735,344.00	296,570,906.85
210301	Гэрэл, цахилгаан	45,968,400.00	49,842,050.00
210302	Түлш, халаалт	73,632,886.00	77,303,860.00
210303	Цэвэр, бохир ус	16,134,058.00	19,424,996.85
210304	Байрны түрээс	150,000,000.00	150,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,596,096.00	29,863,228.00
210401	Бичиг хэрэг	6,195,675.00	7,064,210.00
210402	Тээвэр, шатахуун	2,853,454.00	1,692,610.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,179,500.00	8,923,000.00
210404	Ном, хэвлэл	3,053,900.00	555,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,412,000.00

Монгол Улсын Консерваторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,313,567.00	10,215,808.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	26,512,735.00	40,082,943.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	111,800.00	150,000.00
210502	Хоол, хүнс	25,480,935.00	38,891,943.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	920,000.00	1,041,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,196,335.00	45,554,088.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,422,000.00	7,373,600.00
210604	Урсгал засвар	18,774,335.00	38,180,488.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	604,000.00	759,900.00
210702	Дотоод албан томилолт	604,000.00	759,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	64,085,050.00	112,462,836.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,057,169.00	101,967,036.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	10,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,040.00	198,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,897,041.00	297,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	51,403,883.43	73,357,303.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,132,796.43	12,888,691.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,271,087.00	60,468,612.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>182,296,850.84</b>	<b>213,312,495.73</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	166,751,170.00	158,142,414.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,184,920.00	24,674,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,566,250.00	133,468,214.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	72,000,000.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	15,545,680.84	55,170,081.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,545,680.84	55,170,081.73
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>15,771,380.08</u></b>	<b><u>24,959,020.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,771,380.00</b>	<b>24,624,100.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,771,380.00</b>	<b>24,624,100.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	15,771,380.00	24,624,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,771,380.00	24,624,100.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(15,771,380.00)</u></b>	<b><u>(24,624,100.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.08	334,920.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		334,920.00

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>7,185,390,255.62</b>	<b>191,859,293.04</b>	<b>-1,376,900,770.30</b>	<b>6,000,348,778.36</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,185,390,255.62	191,859,293.04	-1,376,900,770.30	6,000,348,778.36
Тайлант үеийн үр дүн			101,092,635.53	101,092,635.53
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>7,185,390,255.62</b>	<b>191,859,293.04</b>	<b>-1,275,808,134.77</b>	<b>6,101,441,413.89</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,185,390,255.62	191,859,293.04	-1,275,808,134.77	6,101,441,413.89
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	825,042,400.00	4,933,703,594.87		5,758,745,994.87
Тайлант үеийн үр дүн			-87,063,684.55	-87,063,684.55
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>8,010,432,655.62</b>	<b>5,125,562,887.91</b>	<b>-1,362,871,819.32</b>	<b>11,773,123,724.21</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,726,790,000.00	3,701,537,006.27	25,252,993.73	99.32
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	3,726,790,000.00	3,701,537,006.27	25,252,993.73	99.32
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	3,565,895,500.00	3,543,778,592.27	22,116,907.73	99.38
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	595,610,300.00	593,708,174.85	1,902,125.15	99.68
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	2,650,093,500.00	2,639,880,182.09	10,213,317.91	99.61
Үндсэн цалин	1,898,111,800.00	1,896,298,960.48	1,812,839.52	99.90
Нэмэгдэл цалин	651,791,700.00	643,391,221.61	8,400,478.39	98.71
Унаа хоолны нэмэгдэл	80,190,000.00	80,190,000.00	0.00	100.00
Урамшуулал	20,000,000.00	20,000,000.00	0.00	100.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	320,191,700.00	310,190,235.33	10,001,464.67	96.88
Тэтгэврийн даатгал	320,191,700.00	310,190,235.33	10,001,464.67	96.88
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	297,060,600.00	296,570,906.85	489,693.15	99.84
Гэрэл, цахилгаан	46,860,000.00	49,842,050.00	-2,982,050.00	106.36
Түлш, халаалт	84,794,600.00	77,303,860.00	7,490,740.00	91.17
Цэвэр, бохир ус	15,406,000.00	19,424,996.85	-4,018,996.85	126.09
Байрны түрээс	150,000,000.00	150,000,000.00	0.00	100.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,765,700.00	30,721,668.00	44,032.00	99.86
Бичиг хэрэг	5,104,700.00	6,458,550.00	-1,353,850.00	126.52
Тээвэр, шатахуун	1,667,600.00	1,692,610.00	-25,010.00	101.50
Шуудан,холбоо, интернетийн төлбөр	11,460,000.00	8,327,100.00	3,132,900.00	72.66
Ном, хэвлэл	2,804,700.00	2,615,600.00	189,100.00	93.26
Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал	2,000,000.00	1,412,000.00	588,000.00	70.60
БҮТЭЗүйлс	7,728,700.00	10,215,808.00	-2,487,108.00	132.18
<b>Нормативт зардал</b>	40,083,000.00	40,082,943.00	57.00	100.00
Эм,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	150,000.00	0.00	100.00
Хоол хүнс	38,892,000.00	38,891,943.00	57.00	100.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,041,000.00	1,041,000.00	0.00	100.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	52,226,700.00	52,224,088.00	2,612.00	99.99
Багаж,техник хэрэгсэл	15,763,800.00	14,043,600.00	1,720,200.00	89.09
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,462,900.00	0.00	1,462,900.00	0.00
Урсгал засвар	35,000,000.00	38,180,488.00	-3,180,488.00	109.09
<b>Томилолт, зочны зардал</b>	1,500,000.00	759,900.00	740,100.00	50.66
Дотоод албан томилолт	1,500,000.00	759,900.00	740,100.00	50.66
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	126,774,300.00	126,462,836.00	311,464.00	99.75
Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	107,075,500.00	106,767,036.00	308,464.00	99.71
Аудит баталгаажуулалт,зэрэглэл	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.00

Монгол Улсын Консерваторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

тогтоох				
Тээврийн хэрэгслийн татвар	198,800.00	198,800.00	0.00	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,500,000.00	9,497,000.00	3,000.00	99.97
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	47,200,000.00	46,885,833.00	314,167.00	99.33
Бараа үйлчилгээний бусад зардал	13,000,000.00	12,888,691.00	111,309.00	99.14
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,200,000.00	33,997,142.00	202,858.00	99.41
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	160,894,500.00	157,758,414.00	3,136,086.00	98.05
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	160,894,500.00	157,758,414.00	3,136,086.00	98.05
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,525,400.00	24,290,200.00	2,235,200.00	91.57
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	134,369,100.00	133,468,214.00	900,886.00	99.33
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,726,790,000.00	3,701,537,006.27	-22,697,851.00	100.61
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	386,472,000.00	409,169,851.00	-22,697,851.00	105.87
Үндсэн үйл ажиллагааны орлого	386,472,000.00	409,169,851.00	-22,697,851.00	105.87
<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	22,500,000.00	29,632,825.00	-7,132,825.00	131.70
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	22,500,000.00	29,632,825.00	-7,132,825.00	131.70
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,317,818,000.00	3,262,734,330.27	0.00	100.00
Улсын төсвөөс санхүүжих	3,317,818,000.00	3,262,734,330.27	0.00	100.00

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,716,130.00	64,716,130.00	0.00	100.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	64,716,130.00	64,716,130.00	0.00	100.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	64,332,130.00	64,332,130.00	0.00	100.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,567,130.00	29,567,130.00	0.00	100.00
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	34,765,000.00	34,765,000.00	0.00	100.00
Үндсэн цалин	34,765,000.00	34,765,000.00	0.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	1,201,560.00	1,201,560.00	0.00	100.00
Бичиг хэрэг	605,660.00	605,660.00	0.00	100.00
Шуудан,холбоо, интернетийн төлбөр	595,900.00	595,900.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,534,100.00	1,534,100.00	0.00	100.00
Багаж,техник хэрэгсэл	1,534,100.00	1,534,100.00	0.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	26,831,470.00	26,831,470.00	0.00	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,831,470.00	26,831,470.00	0.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	384,000.00	384,000.00	0.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	384,000.00	384,000.00	0.00	100.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж,урамшуулал	384,000.00	384,000.00	0.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,716,130.00	64,716,130.00	0.00	100.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,716,130.00	64,716,130.00	0.00	100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	64,716,130.00	64,716,130.00	0.00	100.00

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.20	Аудитын нэр:	Монгол улсын консерваторын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол улсын консерватор			САГ-2019/137/СТА-ТШЗ
Мянган төгрөгөөр				

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нярав нь санхүүгийн програмгүй, анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн, мөн тайлангийн эхний үлдэгдлийг хураангуй зөвхөн орлого, зарлага гаргасан бараа материалын үлдэгдлээр бүртгэж байна.		Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч	Ц.Пүрэвхүү
2	Үндсэн хөрөнгөнд 979,145 төгрөгийн 3 нэр төрлийн хөрөнгөнд цаашид ашиглах жилийг нь оруулаагүйгээс элэгдэл тооцоолж бодоогүй байна. Мөн элэгдэлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө их байна.	979.1	Зөвлөмж өгөх	Тооцооны нягтлан бодогч	Д.Батдэлгэр
	<b>Дүн</b>	<b>979.1</b>			